



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/16

Бор-Өндөр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны Бор-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан “Бор-Өндөр сумын 1-2 багуудад явган хүний зам хийх” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

А.Өлзийсүрэн

Бэлчээр тэжээл, газар тариалан
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

У.Дөлгөөн-Учрал

Үнэлгээний хорооны гишүүн

Х.Мөнхбаяр


Хөндлөнгийн гишүүн

Б.Идэрбаяр

Хөндлөнгийн гишүүн

2. Бор-Өндөр суманд “Бор-Өндөр сумын 1-2 багуудад явган хүний зам хийх” ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохих хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ